

Оюу Толгой ХХК-ийн Ерөнхийлөгч, Гүйцэтгэх ерөнхий захирал Крэйг Киннел Хонконг-д болсон Монголд хөрөнгө оруулагчдын чуулга уулзалт дээр үг хэлэв

Эрхэмсэг сайд нар аа, Монголын болон олон улсын төлөөлөл, эрхэм зочид оо,

Өнөөдөр та бүхэнтэй уулзаж байгаадаа туйлын баяртай байна. Намайг Крэйг Киннел гэдэг, би Оюу Толгой ХХК-ийн Ерөнхийлөгч бөгөөд Гүйцэтгэх ерөнхий захирлаар ажилладаг.

Та бүхний зарим нь Оюу Толгойг сайн мэддэг, зарим нь тийм ч сайн мэдэхгүй байх. Ийм учраас Оюу Толгойд хүрэлцэн ирсэн зочдод үзүүлдэг төслийн тухай богинохон видео танилцуулгаар илтгэлээ эхэлье.

Видео бичлэгийн сүүлийн хэсгээс Оюу Толгойд аюулгүй ажиллагаа бол амин чухал зүйл болохыг анзаарсан байх. Манай компанийн аюулгүй ажиллагааны үр дүн сайн байгаа, гэхдээ үүгээр өөрсдийгөө тайвшруулж болохгүй. Энэ талаар би тун удахгүй арай дэлгэрүүлж ярих болно.

Миний хувьд компанийн захирлын албан тушаалд томилогдоод сар хагас болж байна. Өмнө нь би Рио Тинто зэсийн группийн маркетинг, арилжааны салбарыг удирдаж байсан юм.

Та нарын зарим нь Монгол орны талаар надаас ч илүү өргөн мэдлэгтэй байгаа. Миний хоёр дахь орон гэр болох Монгол улсын талаар, бас Монголын компанийг удирдахад ямар үүрэг, хариуцлагатай байвал зохих вэ гэдэгт суралцах зүйл олон байна. Энэхүү сэтгэл хөдлөл, уламжлал, хүсэл тэмүүлэлээр дүүрэн оронд эхнэр, охиныхоо хамт шинэ амьдралаа эхлүүлж байгаадаа би маш их баяртай байна. Монгол улс бахархал бүхий баялаг түүхтэй орон. Мөн ирээдүйгээ хуучны уламжлал дээр биш харин хамгийн оновчтой зүйл дээр тулгуурлан цогцлон байгуулахыг хүсч байгаа улс юм.

Миний бие Монгол улсын талаар эерэг сайхан итгэл үнэмшилтэй ирсэн гэдгээ хэлмээр байна. Миний удирдаж буй Оюу Толгой ХХК-ийн маш их ажилсаг баг хамт олон энэхүү өндөр сэтгэгдлийг минь улам бэхжүүлж өгсөн. Манай компанийн 8,500 гаруй ажиллагсадын хичээл зүтгэл надад ихээхэн урам зориг өгч байна.

Хэдийгээр би өмнө нь Рио Тинтогийн салбар нэгжүүдийг удирдаж байсан туршлагатай ч Монголд ирэхээс өмнө надтай уулзсан хүн бүр Оюу Толгой бол онцгой төсөл шүү гэж хэлж байсан. Энэ бол маш том компани –дэлхийн гуравдахь том зэсийн үйлдвэр болж хөгжих ирээдүйтэй, харин газарзүй, соёл иргэншил, нийгэм-улстөрийн хувьд маш өвөрмөц орчинд байгаа нэгэн үйлдвэр юм.

Манай компанийн хөгжил дэвшил нь Монгол улсын эдийн засгийн өсөлттэй нягт холбоотой учраас бидний өмнө асар өндөр хариуцлага ногдож байгааг бид бүрэн ухамсарлаж байна. Оюу Толгой одоо дэлхийн зах зээл дээр борлуулалт хийж

үйдвэрлэлийн үйл ажиллагаагаа хэвийн явуулж буй зэсийн бизнес мөн. Оюу Толгой Монгол улсыг урт хугацааны хөрөнгө оруулалтын орон болгох зорилтод хүрэхэд хувь нэмрээ хэдийнэ оруулж эхэлсэн билээ. Тухайлбал,

- Төслийг эхлүүлэх зөвшөөрөл авах үед гадаадын шууд хөрөнгө оруулалт 55 саяас 470 сая гаруй ам.доллар болтлоо өссөн.
- Барилга бүтээн байгуулалтын ажлаа эхэлснээс хойш манай компанийн 1,500 гаруй бэлтгэн нийлүүлэгч өсөн дэвшиж Монгол улсад шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ, мэдлэг чадварыг бий болгосон юм.
- Бид Монголын уул уурхайн салбарт дэлхийн тэргүүний техник технологи, туршлага нэвтрүүлж байна. Аюулгүй ажиллагаанаас эхлээд байгаль орчны технологи, нөхөн сэргээлт хүртэлх чиглэлээр Монголын уул уурхайн салбар хөгжихөд бид түлхэц өгч, тус дэм болсон гэж найдаж байна.

Гэхдээ энэ бүхэн компанийн урт удаан ирээдүйтэй харьцуулбал өчүүхэн бага хугацаанд хийж амжуулсан ажил юм. Компанийн хөгжлийн дараагийн үе шат руу чиглүүлэн хөтлөх үүрэг надад оногдож байна.

Оюу Толгойн барилга, төлөвлөлтийн үе шат амжилттай дуусч үйлдвэрлэл, өргөтгөлийн үе шат руу шилжиж байгаа энэ мөчид Монгол улсад ажиллах томилолтоо эхэлж байгаа миний бие цаашид дөрвөн гол чиглэлд анхаарлаа төвлөрүүлэн ажиллах болно. Үүнд, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, төслийн үр ашиг, үйл ажиллагаа явуулахад нийгмийн дэмжлэг авах болон бизнесийн цаашдын өсөлтийг хангахад чиглэсэн бэлтгэх ажлууд багтаж байна.

Нэг. Аюулгүй ажиллагааны тухай

Ажиллагсадынхаа аюулгүй ажиллагааг бид тэргүүнийхээ зорилт гэж үздэг. Ашиг орлого хэчнээн өссөн ч, бизнесийн ямар ч амжилт гаргасан ч тэдгээр нь хөдөлмөр эрхэлж буй хүмүүст сөргөөр нөлөөлөхийг бид хүлээн зөвшөөрөхгүй. Оюу Толгойд аливаа ажлыг осол авааргүй хийж чадахгүй л бол тэр ажлыг бид хийхгүй.

Рио Тинто компани Оюу Толгой төслийн менежментийг хариуцах болсноос хойш 85 сая гаруй хүн/цаг хүний амь нас эндэж, осолдолгүй ажиллалаа.

Энэ бол аюулгүй ажиллагааны хувьд маш өндөр үзүүлэлт бөгөөд Рио Тинтогийн дэлхийн хэмжээний гүйцэтгэлтэй харьцуулсан ч сайн үзүүлэлт юм. Гэхдээ бид өөрсдийгөө тайвшруулж болохгүй. Бид энэ талаар тууштай, мөн хүчин чармайлт гарган ажиллаж ирсэн, цаашид ч аюулгүй ажиллагааг нэн тэргүүнд тавьж ажиллах болно.

Хоёр. Үнэ цэн. Компанийн үйл ажиллагааг хамгийн үр ашигтай, хамгийн оновчтой болгох тухай.

Бүтээгдэхүүнээ уурхайгаас гарган хэрэглэгчдэд хүргэхэд зарцуулсан хичээл зүтгэл, инерцээ бид үйлдвэрлэлийн үр ашгийг тогтвортой байлгаж, улмаар нэмэгдүүлэх гэсэн шинэ зорилго, зорилтод хүрэхэд зориулах нь нэн чухал. Гэхдээ олон тэрбум ам.долларын өртөг бүхий цогцолборыг ашиглалтад оруулж цаашид ямар ч асуудалгүй жигд ажиллана гэж үгүй.

Манай төслийн хувьд анхны өвлийг өнтэй давах нь хамгийн том сорилт мөн. Энэ бол амаргүй ажил. Рио Тинто -40, +40 хэмийн орчин нөхцөлд уурхай барьж ажиллуулж байсан туршлагатай боловч аль алийг нь тэсвэрлэх чадвартай уурхайг барих шаардлага өмнө нь гарч байгаагүй гэж бодож байна. Энэхүү эрс тэс уур амьсгалтай нөхцөлд үйлдвэрлэлээ зогсолтгүй үргэлжлүүлэн явуулахын тулд биднээс асар их хичээл зүтгэл, шинэлэг санаа шаардах болно.

Гурав. Үйл ажиллагаа явуулахад нийгмийн дэмжлэг авах тухай.

Та нөхдийн зарим нь үүнийг зөвхөн зардал гэж үзэх байх. Харин Оюу Толгой хувьд энэ бол бидний ажил амьдралын салшгүй чухал хэсэг мөн.

- Бид экспортоо эхлэхээс өмнө Монголын Засгийн газарт нэг тэрбум гаруй ам.долларын татвар, төлбөр, шимтгэл төлсөн билээ.
- Сургалт, боловсролын чиглэлд бид 126 сая ам.долларын хөрөнгө оруулалт хийлээ. Энэ нь зөвхөн уул уурхайд биш, бусад салбаруудын ажиллах хүчинд ч эерэг нөлөө үзүүлэх болно.
- Бид байгаль орчин, нийгэмд үзүүлж буй нөлөөллийн талаар нутгийн иргэдтэй байнга зөвшилцдөг. Хэрэглэсэн усаа дахин ашиглах дэлхийн тэргүүн туршлагыг нэвтрүүлж, үйл ажиллагаагаа явуулж буй орон нутгийн эзэд болох иргэдийн амьжиргааг дээшлүүлэхэд чадах бүхнээ бид хийж байна.

Өмнийн говийн ард иргэдтэй хэл амаа ололцон харилцан ойлголцоход асар их цаг хугацаа зарцуулах шаардлагатай байна. Манай компани юу хийж байгааг илүү их мэдэхийг хүсч байна, гэвч түүнээс чухал зүйл юу гэвэл бид тэдэнтэй хамтран ажиллаж, хүсэлтийг нь сонсон хүлээн авч байна гэдгээ бодитоор харуулах ёстой. Бид хүлээсэн үүрэг амлалтдаа үнэнч хэвээр байгаа гэдгээ өмнийн говьд ч, Монгол улсын хэмжээнд ч монгол хүн бүрт нотлох учиртай.

Дөрөв. Компанийг ирээдүйн өсөлт, өргөжилтөд бэлтгэх тухай.

Та бүхэн намайг нэг л асуултад хариу өгөөсэй гэж хүлээж суугаа байх.

Оюу Толгой төслийн санхүүжилт болон далд уурхайн асуудал хэзээ шийдэгдэж тодорхой болох вэ гэсэн асуулт бий.

Энэ асуултад өгөх хариу надад хараахан байхгүй байна.

Миний хувьд, та бүгдийн нэгэн адил, хэлэлцэж буй асуудлыг нааштай шийдвэрлэх тэр өдөр ирнэ гэж итгэж байна. Он цагийн шалгуурыг давж чадахуйц харилцан итгэсэн түншлэл дээр бат сууриласан илүү сайн, илүү хүчирхэг Оюу Толгойг бий болгосон байдлаар амжилтыг хэмжинэ.

Би далд уурхайд хоёр долоо хоногийн өмнө анх очсон юм. Тэнд үлдсэн цөөхөн ажилчид хийж бүтээсэн зүйл, олсон амжилтаараа бахархаж байгааг харахад сэтгэл маш их хөдөлж байлаа. Далд уурхайд нэгэнт гүйцээж дуусгасан ажлын чанарыг үнэхээр гайхалтай гэж хэлэхээс өөр аргагүй.

Иймээс энэхүү гайхамшигтай ажлыг дахин эхлүүлэх тэр өдөрт бид одооноос бэлтгэх болно. Оюу Толгойн далд уурхай дэлхийн хэмжээний амжилттай төсөл болно гэдэгт би бүрэн итгэж байна. Түүнд бид бэлтгэлтэй байх ёстой. Иймд бид ажилчдынхаа өсөлт хөгжилт, ялангуяа Оюу Толгойн ирээдүйн удирдагчдыг бэлтгэх ажилд хөрөнгө оруулсаар байх болно. Бид ийм ирээдүйтэй хэд хэдэн залуу монгол менежерийг саяхан үүрэгт ажлаас нь түр чөлөөлж компанийг удирдан жолоодох ажилд бэлтгэж эхлээд байна. Тэд арван найман сарын турш эзэмшсэн мэргэжлээс өөр урьд өмнө нь ажиллаж байгаагүй хэлтэс, нэгжид хүнд хэцүү ажлыг хийх болно. Тэд маш их ачаалалтай ажиллаж байгаа бөгөөд хөтөлбөр дуусахад Оюу Толгой компанийг ирээдүйд удирдах чадвартай болох юм.

Гүйцэтгэх ерөнхий захирлын хувьд хийх ажлын төлөвлөгөө маань энэ юм. Үнэ цэнийг одоо бий болгох, эсвэл ирээдүйн өсөлтөд бэлтгэхэд ч бид сайтар бодож нухацтай шийдвэрээ гаргах болно.

Оюу Толгойчууд бид дөчин жил, жаран жил, магадгүй зуун жил үргэлжлэх уурхайн анхны удирдагч нар мөн билээ. Бид энэ бүхнийг хойч үеийнхнийхээ төлөө, бидний үр сад, ач зээ нарын төлөө хийж байна.

Өнөөдөр хэт яарч, цаашид 50 гаруй жилийн туршид саад бэрхшээлтэй тулгарч байснаас энэ удаа арай ахиу цаг зав зарцуулж, асуудлаа зөв шийдвэрлэх нь нэн оновчтой алхам болно.

Оюу Толгойн үр шимийг хүн бүрт яаж хүргэх вэ, Оюу Толгойг тасралтгүй үргэлжлэх улстөрийн маргаан бус, харин компани-бизнес гэдгээр нь хэрхэн хөгжүүлэх вэ гэдэг асуудлаар хэлэлцүүлэг өрнөж байгааг бид ажиглан харж байна.

Оюу Толгойн талаар өрнөж буй маргаан нь буруу зам руу орсон болов уу гэж заримдаа бодогддог. Бидний түншлэлийг хэтэрхий хялбарчилж, нэг тал нөгөөдөө юу өгч чадах, Монголын нөөц баялгийг олон улсын туршлага, хөрөнгө оруулалтаар солилцох гэх мэт наймаалцах өнгө аяс ажиглагдах болсон нь учир дутаглалтай юм.

Гэхдээ ийм маягийн тайлбар өгөх нь Оюу Толгой бол хоёр тэс өөр бүрэлдэхүүн хэсэг биш, салшгүй нэг тал гэдгийг мартагдуулахад хүргэж байна. Тийм ээ, олон улсын хөрөнгө

оруулагчид болон Засгийн газар хоёр өөр хувь нийлүүлэгчид мөн. Гэхдээ тэд Оюу Толгой дээр нэг баг болж ажилладаг. Төсөлд талуудын оруулж байгаа хувь нэмэр хэдий чухал ч тэд ингэж нэг баг болсны хариуд хүртэх үр шим нь аль аль талынх байх бөгөөд дотроо задарч хуваагдахгүй юм. Бид Засгийн газар, Туркойз Хилл, Рио Тинто гэдгээрээ биш, Оюу Толгой гэдгээрээ өгсөх үедээ хамтдаа өгсөж, уруудах үедээ хамтдаа уруудна.

Эдүгээ Монгол улс эдийн засгийн өөрчлөлтийн саад бэршээлтэй тулгарч байгаа хэдий ч дэлхий нийтээрээ Оюу Толгой юу бүтээж чаддагийг харж байна.

Оюу Толгой бол үйлдвэрлэлээ явуулж, дөнгөж орлого олж эхэлж байгаа дэлхийн түвшний компани билээ. Бид аюулгүй ажиллагаандаа анхаарлаа төвлөрүүлэн нийгэмд үйл ажиллагаагаа хүлээн зөвшөөрүүлэхийн төлөө ажиллаж байна.

Цаашид бид улам их нэмүү үнэ цэнийг бий болгох болно. Бидний өмнө олон жилийн ирээдүй бий. Харин бид энэ он жилүүдэд бэлтгэх ажлаа одооноос хийж эхэлж байна.

Манай ажилчид Оюу Толгойг ойлгож, хүлээн зөвшөөрдөг шиг бусад хүмүүсийн дэмжлэг авахын тулд мөн бидний бий болгосон түншлэлийг хамгийн дээд зэрэгт хүргэхийн тулд биднээс маш их хүчин чармайлт, хичээл зүтгэл шаардах болно. Энэ залуус надад Оюу Толгойд ирсэн өдрөөс эхлэн урам зориг өгч байна. Тэд хүнд хэцүү салбарт, хатуу бэрх орчинд өдөр бүр хичээл зүтгэл гарган ажилладаг юм.

Бид хамтдаа хийж чадсан ажлаараа ямагт бахархдаг. Ирэх он жилүүдэд зорилгодоо ийнхүү үнэнч тууштай байж, хүчин чармайлт гарган ажилласнаар Оюу Толгойг дэлхийн хэмжээний Монголын амжилтын түүх мөн гэдгийг биднийг хамгийн их шүүмжилдэг шүүмжлэгчдэд хүртэл батлан харуулж чадна.

Монгол дахь томилолтоо би өөдрөг сэтгэл, зоригтой, шийдэмгий байдлаар эхэлж байна.

Монголын талаар хэдийнэ мэдлэгтэй болсон, эсвэл над шиг сурах зүйл ихтэй хүмүүст ч хөрөнгө оруулалтын орчны тухай энгийн ойлголт бий. Оюу Толгойн өнцгөөс харах эсвэл бусад бизнесийн итгэлийг аваад үзсэн Монгол улсад асар их боломж байна. Үүнд ихээхэн цаг хугацаа шаардагдана. Гэсэн ч эцсийн эцэст бид асуудлаа зөвөөр шийдвэрлэх болно.

Энэ сайхан улсад өрнөж буй гайхалтай төсөлд хувь нэмрээ оруулж байгаадаа би маш их баяртай байна. Та бүхнийг Монголын гайхамшигтай түүхэнд өөрийн гэсэн байр сууриа лавтайяа олж чадна гэдэгт би итгэл дүүрэн байна.